

СОЁЛЫН ӨВИЙН ТӨВ

**ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ
2008 ОНЫ БИЕЛЭЛТИЙН
ТАЙЛАН**

**СОЁЛЫН ӨВИЙН ТӨВИЙН 2008 ОНЫ
БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭЛТИЙГ
ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2009 ОН**

Соёлын өвийн төвийн 2008 оны бүтээгдэхүүн

нийлүүлэлтийг хангах үйл ажиллагааны тайлан

Бүтээгдэхүүний анги -1

1. Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээлэх үйлчилгээ

1.1 “Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр”-ийн хүрээнд улс, аймгийн музей, утга соёлын өвийн төвөөс дэлгэрэнгүй бүртгэн баримтжуулсан үзмэрийн талаарх мэдээлэл, хэрэглэгдэхүүнийг графикайн дагуу хүлээж авах талаар:

- 35 байгууллагатай “Соёлын өвийн төвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд бүртгэл ирүүлэх гэрээ”-ний хавсралт №1-д заасны дагуу програм хангамжийг ашиглан интернетээр бүртгэл авах, УНБМСанг бүрдүүлэх

“Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр”-т хамрагдаж байгаа музей, эрдэм шинжилгээний байгууллагаас одоогийн байдлаар Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд Хэнтий аймгийн музей 62 ш, Завхан аймгийн музей 40 ш, Дархан-Уул аймгийн музей 21 ш, Увс аймгийн музей 1 ш, Баян-Өлгий аймгийн музей 50 ш, Сүхбаатар аймгийн музей 40 ш, Сэлэнгэ аймгийн музей 4 ш, Орхон аймгийн музей 7 ш, Өвөрхангай аймгийн музей 107 ш үзмэрийн бүртгэлийг туршилтын журмаар тус тус ирүүлсэн байна.

Улсын чанартай болон аймгийн музейнүүдэд сан хөмрөгийн улсын тооллого 2007 оны 10 дугаар сараас эхлэн 2008 оныг дуустал явагдаж музейн хүн, хүчний ихэнх нь тооллогын ажилд оролцож, шинэ програмын дагуу бүртгэл хийж, УНБМСанд ирүүлэх ажил түр хойшлогдсон.

Соёлын өвийн УНБМСанд ирсэн дээрх 9 аймгийн 332 бүртгэлийг хянаж үзээд бүрдүүлэлт дутуу, тодорхойлт бичилт шаардлагын түвшинд хүрэхгүй байгаа тул дээрхи музейнүүдэд бүртгэл бүрдүүлэлтийн талаарх заавар зөвлөмжийг хүргүүлсэн.

Энэхүү хөтөлбөрийн үр дүнд Улаанбаатар хотын 9 музей, 20 аймгийн музей интернет сүлжээнд холбогдсон ба ганцхан Хөвсгөл аймгийн музей барилгын асуудлаас шалтгаалж интернет сүлжээнд холбогдоогүй байна.

- Утга соёлын өвийн төвтэй гэрээ байгуулан тус төвийн бүртгэн баримтжуулсан хэрэглэгдэхүүнийг 1 хувь хувилан Улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд хадгалах

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 302-р тогтоол, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 47-р тушаалын дагуу Соёлын өвийн төвийн үйл ажиллагааг өргөжүүлэн “Утга соёлын үндэсний төв” төрийн бус байгууллагыг Соёлын өвийн төвтэй нэгтгэхийг заасан нь утга соёлын өвийн бүртгэн баримтжуулагдсан хэрэглэгдэхүүнийг улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд бүртгэх, биет бус соёлын өвийн бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх боломжтой болсон юм.

“Утга соёлын үндэсний төв” ТББ-д цуглагдсан тоног төхөөрөмжийг хүлээн авах комисс 41 ширхэг тоног төхөөрөмж, 60 ширхэг материал туслах хэрэглэгдхүүн, 27 ширхэг тавилга эд хогшил тус төвийн бүртгэлд байгааг ялган төрөлжүүлэн бүртгэлээ.

Үүнээс 11 ширхэг техник тоног төхөөрөмж, 60 ширхэг материал туслах хэрэглэгдхүүн, 5 ширхэг тавилга эд хогшлыг ашиглалтын хугацаа дууссан цаашид ашиглах боломжгүй, эвдэрсэн, гэмтсэн тул хасахаар санал гаргав. Жишээ нь: 60 ширхэг хасахаар санал болгосон материал туслах хэрэглэгдхүүний 54 ширхэг нь ашиглалтын хэмжээ нь дууссан батерей, эвдэрхий батерей цэнэглэгч гэх мэт эд зүйлс байна.

Ингээд комисс 30 ширхэг техник тоног төхөөрөмж, 22 ширхэг тавилга, эд хогшлыг Соёлын өвийн төвийн тоног төхөөрөмж, эд хогшилд бүртгэж аван 2009 онд Төрийн өмчийн хороонд бүртгүүлэхээр боллоо. Соёлын өвийн төвд бүртгэгдсэн тоног төхөөрөмж, эд хогшил, биет бус оёлын өвтэй холбоотой цуглагдсан эх хальс, хуулбар хальс, бусад мэдээлэл зэргийг ажилтнуудад тус тусад нь хувиарлан өгч эд хогшил эзэмшигчийн жагсаалт дэвтэр үйлдэн хүлээлгэн өглөө.

Мөн 1997 оноос хойш цуглагдсан 504 цагийн дүрс бичлэгийн хальс, 280 цагийн аудио дууны хальс, 800 гаруй биет бус соёлын өвийг тээгчтэй холбоотой мэдээллийг Соёлын өвийн төвийн Биет бус соёлын өвийн бүртгэл-мэдээллийн санд шилжүүлэхдээ тусгайлан дугаар өгч эмх цэгцтэй байдлаар сан бүрдүүлэх, эх оргиналь хальсыг далд сан хөмрөгт хадгалах үйл ажиллагааг хийхдээ эх хальснаас mini DVcam, DVD хоёр хэлбэрээр тус бүрээс 2 хувь хуулбарыг хийж хадгалах нь зүйтэй гэж үзлээ. Тус төвийн сан хөмрөгт хадгалагдаж буй:

-Betacam 30мин оргиналь хальс 337 ширхэг 168 цаг

-UVW 60-90 мин оргиналь 66 ширхэг (20ш-60мин) 89 цаг

-DGL оргиналь хальс 275 ширхэг 227 цаг

-VHS оргиналь хальс 20 ширхэг 20 цаг

-DAT дууны оргиналь хальс 140 ширхэг 280 цаг болон бусад хуулбар хальс бичлэгийг үе дараалалтайгаар дугаар бүртгэлжүүлэн, баримтжуулж архивын тогтолцоонд оруулж хуулах ажлыг хийж байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 125-р тушаалын дагуу Соёлын өвийн төвийн бүтэц, дүрмийг өөрчлөн манай байгууллага Биет соёлын өвийг хамгаалах хэлтэс, Биет бус соёлын өвийг хамгаалах хэлтэс, Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, сэргээн засварлах хэлтэс гэсэн үндсэн 3 хэлтэстэй болсноор биет ба биет бус соёлын өвийг цогц байдлаар бүртгэх, улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулж байна. Утга соёлын өвийн төвийн техник тоног төхөөрөмжийг бүртгэх, тус төвд бүртгэгдсэн 800 гаруй ардын билэг авъяастны дуу, дүрс бичлэгийн хальсийг эх хувь болон хуулбар байдлаар бүртгэл-мэдээллийн санд хадгалах, биет бус өвийн бүртгэл-мэдээллийн сангийн үйл ажиллагааны хэтийн зорилгыг боловсруулан ажиллаж байна.

- Хөтөлбөрийн үйл ажиллагааг вэб сайтаар мэдээлэх, сурталчлах

Соёлын өвийн төвийн www.monheritage.mn веб сайтаар “Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр”-ийн хүрээнд хийгдэж буй ажлууд болон соёлын өвийн бүртгэн баримтжуулалтын талаарх сүүлийн үеийн мэдээ мэдээллийг цаг алдалгүй мэдээлж байна. Уг веб сайтаар дамжуулан хөтөлбөрт хамрагдсан музей, байгууллагын ажилтнууд бүртгэлийн талаар өөрт тулгамдсан асуудлаа шийдвэрлүүлэх, музей хоорондоо туршлага, мэдээлэл солилцох үйл ажиллагааг байнга идэвхтэй явуулан ажиллаж байна. Бид өөрийн веб сайтанд улсын чанартай болон бүх аймгийн музейн танилцуулгыг байршуулах ажлыг хийж бэлэн болгоод байна.

- Бүртгэлийн програм хангамж өгөгдлийн баазыг шинэчилж сайжруулах

Тус хөтөлбөрийг хэрэгжүүлж ирсэн өнөөдрийг хүртэлх хугацаанд орон нутгийн болон улсын чанартай музейн бүртгэл-мэдээллийн сангийн ажилтнууд бүртгэлийн RCH програмыг эзэмших байдал, интернет сүлжээ болон компьютерийн үндсэн мэдлэг хангалтгүй болох нь харагдсан юм.

Эдгээр шалтгаанаас үүдэн бүртгэлийн програм ажиллах зориулалт бүхий компьютерийг вирустүүлэх, бүртгэлийн програмын хэвийн үйл ажиллагааг хангахгүй болгох тохиолдол гарсаар байна. Улмаар бүртгэлийн програмыг засах, дахин шинээр суулгах, үйлдлийн системийг дахин суулгах зэргээр компьютерийн процессорыг Соёлын өвийн төв рүү олон дахин зөөх явдал гарч маш их цаг, хөрөнгө мөнгө зарцуулж байгаа. Процессорыг олон дахин зөөвөрлөх нь техникийн гэмтэл гарах, ялангуяа хард диск гэмтэж, хадгалагдсан мэдээлэл устах зэрэг олон эрсдлүүдийг дагуулдаг болно.

Иймд тулгарч буй энэхүү асуудлыг шийдвэрлэхийн тулд Соёлын өвийн төвийн хүсэлтээр интернэт сүлжээ ашиглан компьютерийг удирдах боломж бүхий “Интернэт удирдлагын програм”-ийг “Сайбер-Андромеда” ХХК-д боловсруулсан улс, аймгийн музейнүүдэд санал болгосон юм. Энэхүү програм нь дээр дурьдсан бэрхшээлтэй асуудал гарсан тохиолдолд Соёлын өвийн төвийн програмист интернет сүлжээ ашиглан харилцагч байгууллагын компьютерт холбогдон RCH бүртгэлийн програм болон Windows орчны зарим асуудлыг шийдвэрлэх боломжийг олгох юм. Ингэснээр ихээхэн цаг хугацаа, хөрөнгө мөнгө хэмнэх боломжтой болсон. Одоогоор энэхүү програм хангамжийг орон нутгийн 3-4 музейд суурилуулсан бөгөөд цаг хугацаа хөрөнгө мөнгийг хэмнэсэн зайлшгүй хэрэгцээтэй сайн програм болсон нь амьдралд батлагдаад байна.

1.2 Түүх, соёлын хосгүй үнэт 274 дурсгалт зүйлийг жагсаалтанд нэмэлт оруулах талаар:

Соёлын өвийн төвөөс хосгүй үнэт зэрэглэлд хамруулах ажлыг зохион байгуулан, Өвөрхангай аймгийн Хархорин сумын Шанхын Баруун хүрээ хийдэд хадгалагдаж байгаа дурсгалуудаас сонгон Боловсрол, соёл, шинжлэх ухааны дэргэдэх Түүх, соёлын дурсгалт зүйлийг зэрэглэл, үнэлгээг тодорхойлох мэргэжлийн зөвлөлийн хуралд санал оруулсан. Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн Засгийн газарт өргөн барьснаар Засгийн газрын 2008 оны 3-р сарын 19-ний өдрийн 103-р тогтоолоор “Түүх соёлын дурсгалт зүйлийн жагсаалт батлах тухай” 1995 оны 12-р сарын 23-ны өдрийн 241-р тогтоолын 1 дүгээр хавсралтад нэмэлт оруулан 15 дурсгал (цутгамал баримал-4, танка зураг-9, монгол зураг-1, хөгжмийн зэмсэг-1)-ыг шинээр хосгүй үнэт зэрэглэлийн дурсгалаар батлагдсан.

Монгол Улсын түүх, соёлын хосгүй үнэт зэрэглэлд батлагдсан Өвөрхангай аймгийн Хархорин сумын Шанхын Баруун хүрээ хийдэд хадгалагдаж буй эдгээр танка зураг, цутгамал баримал, дархан их бүрээ хөгжмийн зэмсэг нь XVII зууны үед, VIII Богдын хөрөг зураг нь XX зууны эхэн үед хамаарах бүтээл юм.

Одоогийн байдлаар 1995-2008 онд Засгийн газрын тогтоолоор нийт 289 дурсгал Монгол Улсын түүх, соёлын хосгүй үнэт зэрэглэлийн дурсгалаар батлагдсан байна.

1.3 Улс, орон нутгийн хамгаалалтанд байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтыг шинэчлэх талаар:

Монгол улсын нутагт сүүлийн 10 гаруй жил явуулсан археологийн хайгуул, малтлага судалгааны үр дүнд түүх, соёл, шинжлэх ухааны өндөр ач

холбогдолтой олон дурсгалуудыг шинээр нээн илрүүлсэн бөгөөд тэдгээрийг зайлшгүй хамгаалалтанд авах, түүнчлэн зарим дурсгалын хамгаалалтын зэрэглэлийг дээшлүүлэх шаардлага зүй ёсоор тавигдсан зэргээс үүдэн улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх, соёлын дурсгалт зүйлийн жагсаалтыг 2008 онд дахин шинэчлэн баталсан.

Засгийн газрын 2008 оны 5-р сарын 14-ний өдрийн 175 тоот тогтоолоор батлагдсан шинэчилсэн жагсаалтад улсын хамгаалалтад 179 дурсгал, аймгийн хамгаалалтад 274 дурсгалыг хамруулсан нь өмнөх 1998 оны жагсаалтаас 101 дурсгалаар илүү байна.

Энэ шинэчилсэн жагсаалтад түүх, соёлын ач холбогдол өндөртэй, хамгаалалтын зэрэглэлийг дээшлүүлэн урт хугацаанд тогтвортой судалгаа, шинжилгээний ажил хийх шаардлагатай 15 дурсгалыг аймаг, нийслэлийн хамгаалалтаас улсын хамгаалалтад шилжүүлэн оруулсан ба шинээр 60 дурсгалыг улсын, 41 дурсгалыг аймгийн хамгаалалтад оруулан нэмж тусгажээ.

Шинэчилсэн жагсаалтыг ШУА-ийн Археологийн хүрээлэн, Палеонтологийн хүрээлэн, Монголын Үндэсний музей, МУИС-ийн Антропологи-Археологийн тэнхим, Улаанбаатарын Их Сургуулийн НУФ зэрэг түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг судлах, сурталчилах, хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага, иргэдээс саналыг авч нягтлан үзсэний үндсэн дээр боловсруулсан.

2008 оны шинэчилсэн “Улс, орон нутгийн хамгаалалтанд байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-д палеонтологийн дурсгалт газрыг анх удаа оруулсанаараа онцлогтой болсон юм.

1.4 Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын нарийвчилсан бүртгэл, тооллогыг Хэнтий, Сүхбаатар аймгийн нутагт хийсэн талаар:

- 2008-2015 онд Монгол Улсын нутгаар түүх, соёлын үл хөдлөх дурсгалын нарийвчилсан бүртгэл, тооллого судалгаа хийхээр төлөвлөсөн ба 2008 онд Хэнтий, Сүх баатар аймгийг хамруулах

Монгол Улсын Сангийн сайд, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайдын 2006 оны 09-р сарын 27-ны өдрийн 299/324/111 тоот хамтарсан тушаалаар “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл болох булш, хиргисүүр, хадны зураг, бичээс, хөшөө чулуу, сүм хийд, түүний үлдэгдэл, эртний хотын туурь, түүхт овоо суврага зэргийг бүртгэн тоолох” ажлыг 2008-2015 онуудад зохион байгуулахаар баталсныг Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 12-р сарын 07-ны өдрийн 244-р тоот тогтоолоор батлагдсан “Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр”-т туссан үл хөдлөх дурсгалтай холбоотой ажлуудтай уялдуулан хийхээр төлөвлөсөн юм.

Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан бүтээгдэгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээнд Дорнод, Сүхбаатар аймаг гэж төлөвлөсөн боловч 2008 онд Хэнтий, Сүхбаатар аймагт орших үл хөдлөх дурсгалыг бүртгэн тоолох ажлыг хийж гүйцэтгэлээ.

2008 оны 5 дугаар сарын 23-наас 7 дугаар сарын 20-ны өдөр хүртэл Соёлын өвийн төвийн мэргэжилтэн Б.Даваацэрэн, сэргээн засварлагч-судлаач Г.Соёл-Эрдэнэ, ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Ц.Болорбат, Н.Баярхүү нараас бүрдсэн хээрийн шинжилгээний баг нь Хэнтий аймгийн 17 сумын нутагт, 2008 оны 8 дугаар сарын 27-ноос 9 дугаар сарын 25-ныг хүртэлх хугацаанд Соёлын өвийн төвийн мэргэжилтэн Б.Даваацэрэн, сэргээн засварлагч-судлаач Г.Соёл-Эрдэнэ, Б.Маргад нараас бүрдсэн хээрийн шинжилгээний баг Сүхбаатар аймгийн 12 сумдын нутагт тус

тус ажиллан түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлст хамаарах булш, хиргисүүр, хөшөө, хадны зураг, бичиг, эртний хотын туурь, сүм хийдийн үлдэгдэл, чулуун зэвсгийн дурсгалт газар, эртний түүхт агуй, овоо зэргийг газар дээр нь очиж үзэн бүртгэж, гэрэл зураг, дүрс бичлэгийн хальсанд баримтжуулж тоолсон байна.

Хээрийн шинжилгээний баг дээрх хоёр аймгийн нийт 29 сумын нутагт 3 сарын турш ажиллахдаа 402 нэр төрлийн 4500 гаруй нэгж үл хөдлөх дурсгалыг бүртгэн тоолж, тэдгээрийг 23700 гаруй гэрэл зураг, 100 гаруй гар зураг, 400 орчим минутын дүрс бичлэгээр баримтжуулсан байна. Бүртгэл тооллогод хамрагдсан 402 нэр төрлийн 4500 орчим дурсгалын 20 гаруй хувь нь шинээр улсын бүртгэлд хамрагдаж байгаа юм.

Түүнчлэн тус баг Хэнтий аймгийн 12, Сүхбаатар аймгийн 7 сумын Соёлын төвийн эрхлэгч, Засаг даргын Тамгын газрын холбогдох албан тушаалтан, байгаль орчны байцаагч нарыг бүртгэл, тооллогын ажилдаа татан оролцуулж, тухайн сумын нутагт байх үл хөдлөх дурсгалыг газар дээр нь үзүүлж дурсгалыг бүртгэх арга зүйн сургалт хийж, шинжлэх ухааны холбогдох мэдээллийг өгсөн. Мөн дээрх сумдын орон нутаг судлах танхимд чулуун зэвсгийн дээж, хот суурины үлдэгдлээс олдсон барилгын элдэв хэрэглэгдэхүүн зэрэг нийт 200 гаруй нэгж олдворыг шинжлэх ухааны тодорхойлолтын хамт хүлээлгэн өгсөн болно.

Мөн Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт шинээр олдсон хоёр ширхэг хүн чулууг аймгийн музейн үүдэнд хамгаалж татаж авахыг зөвлөсөн байна.

Хээрийн судалгааны ажлаар цуглуулсан үл хөдлөх дурсгалын бүртгэн баримтжуулалтын хэрэглэгдэхүүнийг улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд хадгалсан. (Хэнтий, Сүхбаатар аймагт ажилласан тухай дэлгэрэнгүй тайланг хавсаргав)

- Бүртгэн баримтжуулах ажил хийх програм хангамж бэлэн болгох, зарим тоног төхөөрөмжөөр хангах

Хээрийн судалгааны багийг хөдөө хээр ажиллах боломжтой цахилгаан үүсгүүр, зөөврийн компьютер, дүрс бичлэгийн камер, газар зүйн байрлалыг тодорхойлох “GPS” зэрэг багаж хэрэгслээр ханган, ажиллах боломж нөхцлийг бүрдүүлсэн.

“Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр”-ийн хүрээнд хээр, хөдөө орших хадны зураг, булш бунхан, хүн чулуу, байшин барилга гэх мэт түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг бүртгэхэд зориулсан “RICH буюу Registration of Immovable Cultural Heritage” програмыг холбогдох газруудтай хамтран боловсруулан бэлэн болгосон. Хэнтий, Сүхбаатар аймгийн нутагт ажиллахдаа дээрх програмыг туршин үзэж зарим засварыг хийж байна.

- Бүртгэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй хийх, экспедици томилох, судалгааны ажлыг эмхэтгэн хэвлэх

Хэнтий, Сүхбаатар аймгийн бүртгэл тооллогод хамрагдсан үл хөдлөх дурсгалуудаас хөшөө чулуун дурсгалыг урд, ар, хажуу талаас нь харуулсан гэрэл зураг, гар зураг болон ерөнхий байдлыг үзүүлсэн гэрэл зураг товч тайлбар бүхий “Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал” гэрэл зургийн цомгийг Хэнтий, Сүхбаатар аймаг тус бүрээр нь нийт 2000 хувь хэвлүүлэн Улаанбаатар хотод байрладаг болон бүх аймгийн музей, номын сан, эрдэм шинжилгээний хүрээлэн, их, дээд сургуулиудын номын сангуудад үнэ төлбөргүй тараагаад байна.

1.5 “Монгол дахь буддын урлаг” каталогийн I ботийг хэвлүүлэх талаар:

“Монгол дахь буддын урлаг” каталогийн I ботийг хэвлүүлэхэд Соёлын өвийн төвөөс номын эх бэлтгэлийг цаг хугацаандаа багтаан бэлэн болгоод байгаа бөгөөд зөвхөн хэвлүүлэх ажил үлдээд байгаа юм.

Энэхүү каталогит монголын бурханы шашны шилдэг 441 дэлгэмэл бүтээлийн гэрэл зураг, монгол, англи тайлбар орсон бөгөөд Монголд бурханы шашны урлаг хөгжсөн түүхэн замналыг эртний үеэс эхлээд XX зуун хүртэлх үеийг хамруулсан товч түүх, монгол, англи үгийн тайлбар толь, бурхадын нэр томъёоны жагсаалт, Монголын түүхийн он цагийн товчоон болон ном зүй, каталогийг бүтээсэн хүмүүсийн товч танилцуулга зэргийг багтаасан.

Хэвлэлтийн ажил нь Англи дахь Төвдийн сан, Тайланд улсын “Сериндиа” хэвлэлийн компаниас шалтгаалан удааширч байна. “Сериндиа” хэвлэлийн компаниас 2009 оны 1-р сард каталогийн туршилтийн хувийг хэвлүүлэн манайд ирүүлэх ба 2009 оны 5 дугаар сард бүрэн хэвлэж дуусгахаа мэдэгдсэн.

Бүтээгдэхүүний анги -2

2. Түүх, соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлах үйлчилгээ

2.1 Улс, аймгийн 10 музейн 150 ширхэг үзмэрийг сэргээн засварлах, зарим хосгүй үнэт үзмэрт хуулбар хийх

Сэргээн засварлах урлан нь 2008 онд 11 музейн 150 үзмэр бүтээлийг сэргээн засварлахаар төлөвлөснөөр Монголын үндэсний музей, Уран зургийн галерей, Дүрслэх урлагийн музей, Улаанбаатар хотын түүх, шинэчилэн байгуулалтын музей, Төрийн түүхийн музей, Богд хааны ордон музей, Өвөрхангай, Булган, Дорнод, Говь-Алтай, Сэлэнгэ, Өмнөговь, Дорноговь, Увс зэрэг аймгийн музейн үзмэр бүтээлийг сэргээн засварлан, хүлээлгэж өгсөн. (Сэргээн засварласан үзмэр бүтээлийн жагсаалтыг хавсаргав.)

Энэ онд сэргээн засварлах ажлын тайлангийн “Маягт А” –г олон улсад мөрддөг маягтын дагуу өөрийн орны онцлог байдалд уялдуулан шинээр боловсруулж, үзмэр бүрийн засварын ажиллагааны өмнөх, явц, гүйцэтгэлийг тайлагнан дэлгэрэнгүй бичиж, жилийн эцэст архивт хадгалж байхаар шийдвэрлэснээр сэргээн засварлагдсан бүтээл, үзмэр бүхэн тодорхойлолт тайлантайгаар сэргээн засварлаж дуусгаад үндсэн байгууллагад нь хүлээлгэж өгсөн. (Сэргээн засварлах тайлангийн маягтА -гийн дагуу бичсэн сэргээн засварласан үзмэрийн тайланг жишээ болгон хавсаргав)

2008 онд сэргээн засварлагдсан бүтээлийг үзмэр хөдөлгөөний актын дагуу хүлээж аваад сэргээн засварлахын өмнөх гэрэл зургуудыг маш дэлгэрэнгүй авсан нь нэг талаар манай сэргээн засварлах ажилд чухал хэрэгтэй ч нөгөө талаар музейнүүд үзмэрийн хадгалалт хамгаалалтанд хэрхэн хандаж байгаа, цаашид үзмэрийн хадгалалт хамгаалалтын талаар заавар зөвлөлгөө өгөх зэрэг ажлууд зохион байгуулах шаардлагатайг харуулж байна.

Хөдөө орон нутгаас үзмэр бүтээлүүдийг тээвэрлэн хүргэж ирэх, буцааж авч явахад бэрхшээл хүндрэл их гарч байгаа нь ажиглагдсан. Үзмэр зөөж тээвэрлэх журмын дагуу өгч авч байгаа музей маш ховор байгаа нь бидний сэтгэлийг зовоож байгаа бас нэг асуудал болж байгааг анхаарах хэрэгтэй байна.

Манай төв нь 2008 оны 7 дугаар сарын 1-нд болсон үймээн самууны үеэр мод чулуу, метал эдлэл сэргээн засварлах урлангийн өрөө галд өртөн тэнд хадгалагдаж байсан “Хар ямаатын голын хөшөө”-ний хэв хуулбар, “Есөн цагаан туг”, Архангай аймгийн музейн үүдэн байрлах “Чонон хөшөө”-ний хуулбар хэв,

“Чин сүжигт номун хийдийн ханын зураг”, Баянхонгор аймгийн Баянлигийн “Бичигтийн хад”-ны хэв хуулбар зэрэг сэргээн засварлаж байсан түүх, соёлын дурсгалууд, сэргээн засварлах ажлын чулуу өргөгч механизм зэрэг техник, тоног төхөөрөмж, ажилтнуудын ажлын багаж хэрэгсэл шатаж, компьютер, микро томруулагч багаж, уран хөрөө, “хонда” мотор техник хэрэгсэл хулгайд алдагдан, эвдрэн сүйрсэн. Гал түймэрийн улмаас гэрэл цахилгаангүй, байгууллагын бүх өрөө тасалгаа, эд зүйлс битүү хар хөө, утаа тортог болсноос хэвийн үйл ажиллагаанд оруулан их цэвэрлэгээ хийхэд 2 сараар ажил саатаж байсан.

Байгууллагын хэмжээгээр 2008 оны 12-р сарын 1-нийг хүртэл гэрэл цахилгаангүй байснаас шалтгаалан хэвийн үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй сэргээн засварлах ажил маш хүнд нөхцөлд явагдаж ирснийг дурдах ёстой. Гэсэн хэдий ч бид төлөвлөсөн ажлуудаа бүрэн хийж гүйцэтгэснээс гадна энэ гал түймэрт гэмтэж бохирдсон Уран зургийн галерейн 10 гаруй бүтээлийг сэргээн засварлах нэмэлт ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

2008 оны 02 дугаар сарын 14-нөөс 03 дугаар сарын 06-ны хооронд Говь-Алтай аймгийн музейн 4 ширхэг “Хүрэл морь”, “Хүрэл баавгай (том)”, “Хүрэл баавгай (жижиг)”, “Хаш бүсгүй” зэрэг ердийн дурсгалаас хуулбар хийх ажлыг Монгол Улсын Засгийн газрын 1994 оны 233 дугаар тогтоолын 2-р хавсралт “хувилан олшруулах, загвараар нь бэлэг дурсгалын зүйл бэлтгэх, кино дүрс бичлэг, гэрэл зураг авах, марк, ил захидал, цомог хийх зориулалтаар түүх соёлын дурсгалт зүйлийн эх бүтээлийг ашиглах журам”-ын 4-ийн “б” заалтыг үндэслэн тус музей, Соёлын өвийн төв харилцан гэрээ байгуулж гүйцэтгэсэн. (Хуулбар хийсэн ажлын тайланг хавсаргав)

2008 оны 9 дүгээр сард Архангай аймгийн Хотонт сумын нутаг Хундын хоолойнд Монгол–Хятадын хамтарсан археологийн судалгааны ангийн олж илрүүлсэн бунхант булшны ханын зургийг эксдедицийн хүсэлтийн дагуу авран хамгаалах зорилгоор дэвсгэр шохойн шаваасны хамт хуулж зөөвөрлөн авчирч төвийн сэргээн засварлах студид сэргээн засварлаж Монголын үндэсний музейд хүлээлгэн өгсөн. (Ханын зургийг бэхжүүлэн сэргээн засварласан ажлын тайланг хавсаргав)

Бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээнд зарим түүх, соёлын хосгүй үнэт зэрэглэлийн үзмэрээс хуулбар хийх ажлыг тусгасан боловч хосгүй үнэт зэрэглэлийн дурсгалын хуулбарыг хийх хууль эрх зүйн нөхцөл бүрдээгүй гэж үзсэнээр хойшлуулсан юм.

Монгол Улсын түүх, соёлын хосгүй үнэт зэрэглэлийн дурсгалын хуулбар хийх ажлыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Улсын мэргэжлийн хяналтын газраас зохих зөвшөөрөлийг авч гэрээ байгуулж гүйцэтгэх нь зүйтэй гэж үзэж байна.

2.2 Бичигтийн амны хадны зурагт бэхжүүлэлт хийж хамгаалах, зарим онцлог дүрслэлийг хуулбарлан Дүрслэх урлагийн музейн эртний танхимд байрлуулах:

2008 оны 5-р сард Дүрслэх урлагийн музейтэй хамтран Баянхонгор аймгийн Баянлиг сумын Бичигтийн хадны өвөрмөц баялаг дурсгалтай хадны зургийн хуулбарыг хийж тус музейд байрлуулах ажлыг эхэлсэн юм.

6-р сарын 25-наас хуулбарыг цутгах ажлыг хийж эхэлсэн хэдий ч 7-р сарын 1-ний үймээний үеэр тус ажлыг гүйцэтгэж байсан өрөө галд өртөж бүрэн шатсны улмаас энэхүү ажил зогссон. (Баянлигийн хадны зургаас хэв авч хуулбар хийсэн ажлын тайланг хавсаргав)

2.3 “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр” –ийн хүрээнд:

“Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр”-т тусгагдсаны дагуу Архангай аймгийн Ихтамир сумын Алтан сандал уулын буган чулуу, Булган аймгийн Баян-Агт сумын Шивээт-Улааны дурсгал, Архангай аймгийн Чулуут голын хадны зураг, Архангай аймгийн Их тамир сумын Тайхар чулуу зэрэг 4 дурсгалт газарт байрлуулах чулуун танилцуулга самбарын эх загварыг гарган, бэлтгэсэн эх загварынхаа “Бодь буян” ХХК-иар хийлгүүлж, дурсгалт газруудад байрлуулахад бэлэн болгосон байна. 2009 онд дээрхи нэр бүхий 4 дурсгалт газруудад танилцуулга самбараа байрлуулна. Энэхүү хөтөлбөрийн төлөвлөлтөнд заасны дагуу:

7.1.2

2008 оны 10 -р сард Дорнод аймгийн Халх гол сумын нутагт байрлах “Их Бурхант” цогцолбор дурсгалыг сэргээн засварлах бэлтгэл ажлын материалын судалгаагаар захирал Г.Энхбат, сэргээн засварлагч С.Чинзориг, сэргээн засварлагч Д.Нямдорж нар тус газарт очиж ажилласан. Халхын Сэцэн ханы Үнэн сүжигт Илдэн хошууны олноо То ван хэмээн алдаршсан жун ван Тогтохтөрийн удирдлагаар 1859-1864 онд байгуулагдсан “Найман аюулаас аврагч Жанрайсиг” бурханы цогцолбор дурсгалыг 2009-2011 онд сэргээн засварлах бэлтгэл ажлыг эхлүүлээд байна. Судалгааны ажилд Дорнод аймгийн музей, “То ван” судлалын нийгэмлэгийн хүмүүстэй хамтран ажилласан. (Дорнод аймагт ажилласан судалгааны багийн ажлын тайланг хавсаргав)

7.2.1

2008 оны 8-р сарын 3-наас 14-ны хооронд Архангай, Өвөрхангай, Булган зэрэг аймгийн нутаг дэвсгэр орших Чинтолгой, Луу гүний хүрээ, Өөлд бэйсийн хүрээ, Цацийн дэнжийн буган чулуу, Тайхар чулуу, Алтан сандал уулын буган чулуу зэрэг дурсгалуудын гэмтэл бохирдлын судалгаа, хэмжилтийг хийж, судалгааны дээж бүрдүүлэх, цаашид хэрхэн хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалт хийх талаар ерөнхий дүгнэлтийг гаргаад байна.

Судалгааны ажлаар Тайхир чулуун дээр бичигдсэн тосон будгийн гэмтэл бохирдлыг цэвэрлэх боломжтойг тогтоов.

7.2.4

2008 оны 8 дугаар сард явсан ажлын хүрээнд Булган аймгийн Дашинчилэн сумын нутаг дахь Цогтын цагаан байшингийн өнөөгийн байдлыг гэрэл зургаар баримтжуулж, хамгаалалтын хашаа барих хэмжээг авч, барилгын хэрэглэгдэхүүний дээжийг шинжилж байна.

7.5.9

2008 оны 9 дүгээр сарын 05-наас 08-ны хугацаанд Япон улсын судлаач мэргэжилтэнгүүдийн хамтаар Хэнтий аймгийн Батширээт сумын Рашаан хадны тамга, тэмдэг, хадны зургийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх, цаашид хэрхэн хамгаалах талаар төлөвлөгөө гаргах зорилгоор Японы эрдэмтэдтэй хамтран хээрийн судалгааны баг тус дурсгалын орчимд судалгаа хийсэн.

7.3.4

Дээрхи Рашааны хадны дурсгалын байдалтай танилцах явцдаа Хэнтий аймгийн Баянхутаг сумын Сэрвэн хаалганы бичээс дурсгалын газар дээр нь

очиж танилцан дурсгалын хамгаалах хамгаалалтын нөхцөлд дүгнэлт судалгаа хийж, цаашид хэрхэн хамгаалах талаар санал солилцон ажиллав. (Монгол-Японы баг Хэнтий аймагт ажилласан ажлын тайланг хавсаргав)

7.7.2

Соёлын өвийг төвийг өргөжүүлэх шинэ барилгатай болгох талаар барилга барих газрын техникийн нөхцөл, барилгын зураг зурах төсвийг 2009 оны төсөвт суулгуулах, барилга барих газрыг олгох талаар БСШУ-ны сайд Улаанбаатар хотын захирагч М.Билэгтэд албан бичиг хүргүүлэв. Соёлын өвийн төвийн шинэ барилгыг барих зураг төслийн талаар Японы мэргэжлийн байгууллагад хандан зөвөлгөө авч, хамтран ажиллахаар болов.

7.6.1-д заасан соёлын өвийг судлах, хамгаалах, сэргээн засварлах чиглэлийн мэргэжилтэн бэлтгэх:

“Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр”-т соёлын өвийн сэргээн засварлагчдын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх өндөр хөгжилтэй орнуудад мэргэшүүлэн сургах тухай заасны дагуу Соёлын өвийн төвийн сэргээн засварлагч зураач Г.Соёл-Эрдэнэ, Г.Ууганчимэг нар БНХАУ-ын Ши-Ань мужийн Барилга архетиктур, соёлын өв хадгалж хамгаалах, сэргээн засварлах төвд 2007 оны 11-р сараас 2008 оны 2-р сар хүртэл сүм хийдийн барилга архитектурын сэргээн засварлах дадлагажилтаар, сэргээн засварлагч-хатгамалчин Б.Мягмарсүрэн, програмист Б.Алтансүх нар Хорват улсын Людбрег дэх сэргээн засварлах төвд 2008 оны 5-р сарын 28-наас 6-р сарын 26-ныг хүртэл соёлын өвийн дижитал хэлбэрийн бүртгэн баримтжуулалт болон сэргээн засварлалтын чиглэлээр 1 сарын дадлагажилтаар, сэргээн засварлагч Д.Нямдорж БНСУ-ын Тэжон хотын Үндэсний соёлын өвийг хадгалж хамгаалах хүрээлэнд чулуу сэргээн засварлах чиглэлээр 2008 оны 5-р сарын 13-наас 8-р сарын 09-нийг хүртэл 3 сарын дадлагажих сургалтанд тус тус хамрагдсан байна. Одоо сэргээн засварлагч Г.Ууганчимэг БНХАУ-д 4 жилийн хугацаатай сэргээн засварлах чиглэлээр “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр”-т соёлын өвийн сэргээн засварлагчдын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх өндөр хөгжилтэй орнуудад мэргэшүүлэн сургах тухай заасны дагуу Соёлын өвийн төвийн сэргээн засварлагч зураач Г.Соёл-Эрдэнэ, Г.Ууганчимэг нар БНХАУ-ын Ши-Ань мужийн Барилга архетиктур, соёлын өв хадгалж хамгаалах, сэргээн засварлах төвд 2007 оны 11-р сараас 2008 оны 2-р сар хүртэл сүм хийдийн барилга архитектурын сэргээн засварлах дадлагажилтаар, сэргээн засварлагч-хатгамалчин Б.Мягмарсүрэн, програмист Б.Алтансүх нар Хорват улсын Людбрег дэх сэргээн засварлах төвд 2008 оны 5-р сарын 28-наас 6-р сарын 26-ныг хүртэл соёлын өвийн дижитал хэлбэрийн бүртгэн баримтжуулалт болон сэргээн засварлалтын чиглэлээр 1 сарын дадлагажилтаар, сэргээн засварлагч Д.Нямдорж БНСУ-ын Тэжон хотын Үндэсний соёлын өвийг хадгалж хамгаалах хүрээлэнд чулуу сэргээн засварлах чиглэлээр 2008 оны 5-р сарын 13-наас 8-р сарын 09-нийг хүртэл 3 сарын дадлагажих сургалтанд тус тус хамрагдсан байна. Одоо сэргээн засварлагч Г.Ууганчимэг БНХАУ-д 4 жилийн хугацаатай сэргээн засварлах чиглэлээр магистрын сургалтанд суралцаж байна. (Сургалтанд хамрагдсан сэргээн засварлагчдын тус бүрийн дэлгэрэнгүй тайланг хавсаргав)

7.6.2-д заасан соёлын өв, түүнийг хамгаалах талаар бүх насны хүмүүст зориулсан танилцуулга, гарын авлага, кино хийх тухай:

Соёлын өвийн төвийн www.monheritage.mn веб сайтаар дамжуулан түүх, соёлын дурсгалыг сурталчлах, мэдээлэл түгээхийн сацуу “Соёлын өв” мэдээлэл, сурталчилгааны сэтгүүлийн анхны дугаарыг 2008 оны 12-р сард эрхлэн гаргасан.

Энэхүү сэтгүүл нь соёлын өвийг хамгаалах чиглэлээр баримталж буй төрийн бодлого, хууль эрх зүй, төрийн болон төрийн бус мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааг танилцуулах, соёлын өвийг хадгалж хамгаалахад олон нийтийн анхаарлыг хандуулах, тэдэнд соёлыг өвийг хадгалж хамгаалах талаар мэдлэг олгоход мэргэжил арга зүйн талаас туслах зорилготой юм. Жилд 2 дугаар хэвлэгдэн гарах бөгөөд тухайн дугаарт хэвлэгдсэн мэдээллийн хураангуйг сэтгүүлийн арын хуудаснаа англи хэл дээр нийтлэн гаргаж байна. “Соёлын өв” сэтгүүлийн анхны дугаарыг 2000 хувиар хэвлүүлсэн.

Бүтээгдэхүүний анги 1.4-д дурьдсан Хэнтий, Сүхбаатар аймгийн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын нарийвчилсан бүртгэл, тооллогод хамрагдсан дурсгалуудыг багтаасан “Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал” 2 боть ном хэвлүүлэн нийтэд түгээсэн.

Соёлын өвийг хадгалж хамгаалах, сэргээн засварлах талаар арга зүйн мэдээлэл өгөх зорилгоор мэргэжлийн байгууллага, иргэдэд зориулан З.Оюунбилэг “Монголын чулуун дурсгалын консервацийн асуудал” ном 300 ширхэг, “Сэргээн засварлагч, зураач Д.Хишигбаяр” дурдатгал ном 300 ширхэгийг тус тус “Сан судай” хэвлэлийн компаниар тус тус хэвлүүлсэн бөгөөд эдгээр сэтгүүл, мэргэжлийн гарын авлага, номнуудыг манай улсын бүх музей, номын сан, эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулийн номын сангууд, бүх аймгийн сумдын соёлын төвүүдэд үнэ төлбөргүйгээр тараагаад байна.

Тусгай захиалгат бүтээгдэхүүн:

Бүтээгдэхүүний анги-1: Соёлын өвийг хамгаалах, улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сан бүрдүүлэх үйлчилгээ

Улс, аймгийн музейн улсын тооллогын дүнг нэгтгэн тайлагнах

Улс, аймгийн музейн сан хөмрөгийн 2007-2008 оны улсын тооллогыг чанар үр дүнтэй явуулахад улсын тооллогын бэлтгэл ажил, явцад хяналт тавих, дүнг тайлагнахад Соёлын өвийн төвөөс голлох үүрэгтэйгээр оролцлоо. Тооллогын бэлтгэл ажлын хүрээнд улс, аймгийн музей, эрдэм шинжилгээний байгууллагын ажилтан, сан хөмрөгч, мэргэжлийн хяналтын байцаагч нарыг оролцуулан 74 хүнд музейн сан хөмрөгт улсын тооллого явуулах сургалт-семинар зохион байгуулж, холбогдох материал, арга зүйг хавсаргасан гарын авлагаар ханган, тооллого хийхэд зориулсан тусгайлсан нэр код бүхий “Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл”-ийн дэвтэр, Улсын стандарт хэмжил зүйн газраар баталгаажуулсан 0-30 кг, 0-100 кг-ын цахилгаан жинг бүх байгууллагад хүлээлгэн өгөх зэрэг ажлуудыг зохион байгуулан ажилласан.

Улсын тооллогын явцад Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 345 дугаар тушаалаар батлагдсан улс, аймгийн музейн сан хөмрөгт улсын тооллого явуулах төв болон салбар комисс улсын 9 музей, Үндэсний номын санд, тухайн аймгийн Засаг даргын захирамж, байгууллагын даргын тушаалаар томилогдсон тооллогын комисс орон нутгийн 21 музей, Археологийн хүрээлэн, Палеонтологийн төв, Улаанбаатар хотын түүх, шинэчлэн байгуулалтын музей нийт 34 байгууллагад 2007 оны 10 дугаар сарын

15-наас 2008 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд улсын тооллогыг зохион байгуулж, Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд бүх байгууллагын “Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл”-ийн дэвтрийн эх хувийг тооллого явуулсан тайлангийн хамт хүлээн авч, улсын хэмжээний нэгдсэн тайлан дүнг гаргалаа.

Тоологдвол зохих 207683 ширхэг байсны 8 музейгээс 3146 ширхэг үзмэр дутсан, 15 музейгээс 141 ширхэг үзмэр хулгайд алдагдсан, 1997-2007 оны хооронд 15 музейгээс 2447 ширхэг үзмэр бусад музейдээ шилжүүлсэн байна. Энэ удаагийн тооллогоор 229 836 ширхэг үзмэр тоологдоод 28 музейгээс 5001 ширхэг актлах саналтай, шилжүүлэх саналтай 18 954 ширхэг үзмэр, Ерөнхий бүртгэлийн дэвтэрт бичигдсэн 206109 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлс байна. Нийт тоологдсон 206109 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлийн 103637 нь улсын музейд, 102472 нь аймаг, байгууллагын музейн сан хөмрөгт хадгалагдаж байна.

Түүнчлэн “Үндэсний соёлын өвийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр”-өөр улс, аймгийн бүх музейд гэрэл зургийн бага оврын студи, компьютер, гурван үйлдлийн хэвлэгчийг олгосон нь тооллогын үеэр музейн бүх үзмэр, эд өлгийн зүйлийг зургийг авч баримтжуулах, тооллогын бүртгэлийг компьютерт шивэхэд чухал ач холбогдолтой боллоо.

Музейн сан хөмрөгийн улсын тооллогонд зориулж анх удаа улсаас тусгайлан хөрөнгө төсвөөс батлагдан 42,0 сая төгрөгийг бүх байгууллагад хуваарилан тооллогын ажлыг түргэн шуурхай зохион байгуулах, ажиллах нөхцөл бололцоо, шаардагдах материал, хэрэгслэлээр хангах, томилолтоор ажиллах зэрэгт зарцуулсан. (Улсын тооллогын нэгдсэн дүнг хавсаргав)

2008 оны үр дүнгийн гэрээнд тусгагдаагүй, нэмэлт ажил:

- Судалгаа, сурталчилгааны ажлын хүрээнд:

- Соёлын өвийн төв үүсэн байгуулагдсаны 20 жилийн ойг 2008 оны 12 дугаар сард зохион байгуулсан бөгөөд энэ ажлын хүрээнд анх байгуулагдсан цагаас эхлэн өнөөг хүртэл 20 жилд хийж гүйцэтгэсэн ажлуудаа тоймлон гэрэл зургийн үзэсгэлэн, байгууллагын үйл ажиллагааг сурталчилах арга хэмжээг зохион байгуулсан.

- Соёлын өвийг хадгалж хамгаалах сурталчлах олон улсын хамтын ажиллагаа, гадаад арга хэмжээний хүрээнд:

- Монголын урлагийн зөвлөл, АНУ-ын Вильямстауны Сэргээн Засварлах Төвийн хамтран зохион байгуулж буй соёлын солилцооны хөтөлбөрийн хүрээнд 2008 оны 4 дүгээр сарын 12-19-ны хооронд Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Соёл, урлагийн газрын музей, түүх, соёлын дурсгал хариуцсан ахлах мэргэжилтэн З.Оюунбилэг, Соёлын өвийн төвийн захирал Г.Энхбат болон Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын өвийн хөтөлбөрийн зохицуулагч Б.Мөнхтуяа нар АНУ-ын Масачусет дахь Вильямстаун хотын Вильямстауны Урлагийн бүтээл Сэргээн Засварлах Төвд (ВСЗТ) айлчилсан. Төлөөлөгчид АНУ-ын 4 хотын нийт 6 музейн үзмэрүүд тэр дундаа 3 байгууллагын үзмэр сан хөмрөг, барилга архитектуртай танилцаж сэргээн засварлагчидтай уулзаж, сэргээн засварлах арга технологи, лабораторийн үйл ажиллагаа, техник тоног төхөөрөмжтэй танилцаж ВСЗТ-ийн удирдлагуудтай цаашдын хамтын үйл ажиллагааны талаар Санамж бичигт гарын үсэг зурсан болно. (АНУ-д хийсэн айлчлалын тайланг хавсаргав)

- Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Испанийн Лакаша сантай хамтран Монгол-Испани улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 30 жилийн ойд зориулан зохион байгуулж буй монголын соёлыг сурталчлах “Монголын нэг өдөр” үзэсгэлэн Испани улсын Валенсио хотод зохиогдоход сан хөмрөгч М.Дэжид 2008 оны 4-р сарын 9-нөөс 20-ны хооронд 10 хоногийн хугацаатай очиж, үзэсгэлэнг дэглэхэд оролцон ажилласан.

- Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Бүгд найрамдах Солонгос улсын Соёлын өвийн захиргааны 2008-2009 онд байгуулсан Санамж бичиг, гэрээний 1-р хөтөлбөрийн дагуу 2008 оны 6 дугаар сарын 09-нөөс 6 дугаар сарын 13-ныг хүртэл БНСУ-д айлчлал хийв. Монголын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Мишигжав, Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн Д.Оюунбилэг, Соёл урлагийн газрын номын сан хариуцсан мэргэжилтэн Д.Баяраа, Монгол улсын циркийн дарга Л.Дорж болон Соёлын өвийн төвийн захирал Г.Энхбат нарын 5 хүн оролцов. (БНСУ-д айлчилсан айлчлалын тайланг хавсаргав)

- 2008 оны 9 дүгээр сард Шинэ Дели хотын Монгол Улсын элчин сайдын яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамаар дамжуулан Энэтхэг улсын Соёл, урлагийн өвийг хамгаалах, сэргээн засварлах байгууллага (INTACH) Монгол улстай соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлах чиглэлээр хамтран ажиллах тухай хүсэлт тавьсныг хүлээн авч судлан, хамтран ажиллах санал хүргүүлсэн. Ойрын үед Монгол Улсын ерөнхийлөгч Н.Энхбаярын Энэтхэгт улсад хийх албан ёсны айлчлалын үеэр соёлын өвийг хадгалж хамгаалах, сэргээн засварлах чиглэлээр хамтран ажиллах Санамж бичигт гарын үсэг зурахаар төлөвлөн ажиллаж байна.

- 2008 оны 11 дүгээр сард Японд улсын Токио хотын соёлын өвийг хамгаалах судалгааны үндэсний хүрээлэнгийн урилгаар БСШУЯамны СУГ-ын дарга Г.Эрдэнэбат, мэргэжилтэн З.Оюунбилэг, СӨТ-ийн захирал Г.Энхбат, ахлах сэргээн засварлагч С.Чинзориг нар 10 хоногийн хугацаатай Япон-Монголын соёлын өвийг хамгаалах талаар хамтран ажиллах талаар судалгааны ажил болон хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулах зорилгоор айлчлав. (Япон улсын Токио хотын соёлын өвийг хамгаалах үндэсний судалгааны хүрээлэнд ажилласан ажлын тайланг хавсаргав).

- Соёлын өвийг хадгалж хамгаалах сургалт семинарын талаар:

- 2008 оны 5 дугаар сард Дэлхийн соёлын өвд бүртгэгдсэн Өвөрхангай аймгийн Хархорины хөндийг хамгаалах менежментийн төлөвлөгөө хийх бэлтгэл судалгааны семинарт оролцсон.

- 2008 оны 9 дүгээр сард Дэлхийн соёлын өвд бүртгэгдсэн Өвөрхангай аймгийн Хархорины хөндийг хамгаалах менежментийн төлөвлөгөө хийх тухай семинарт оролцсон.

- 2008 оны 9 дүгээр сарын 10-11 -ний өдрүүдэд Япон улсын Токио хотын Соёлын өвийг хамгаалах судалгааны институт, Японы Соёлын өвийг хамгаалах Олон улсын конзерциумын дэмжлэгтэйгээр Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаман дээр зохиогдсон “Монгол-Японы соёлын өвийн хадгалалт хамгаалалт” сэдэвт семинарт оролцож, илтгэл тавьсан.

- 2008 оны 10 дугаар сард Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний хорооноос хамтран зохион байгуулсан “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, бүртгэн баримтжуулах” семинарт оролцож, илтгэл тавьсан.

- Соёлын өвийг хамгаалах хууль эрх зүйн орчинг сайжруулахад:

- 2008 оны 11 дүгээр сард Соёлын өвийг хамгаалах тухай хуулийг шинэчлэхтэй холбогдуулан хуулинд нэмэлт оруулах, зарим заалтыг өөрчлөх саналыг боловсруулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд хүргүүлсэн.

- Соёлын өвийн төвийн бүтэц, бүрэлдэхүүн өргөжиж байгаатай холбогдуулан Соёлын өвийн төвийн дүрэм, бүтцийг шинэчлэн боловсруулж, 2008 оны 12 дугаар сард Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдаар батлуулах ажлыг хийж гүйцэтгэсэн.

-Бэхжүүлэлт, сэргээн засварлалтын чиглэлээр

- Архангай аймгийн Хотонт сумын нутагт орших Хундын хоолой хэмээх газар буй Уйгарын үед холбогдох бунхант булшны малталтаас гарч ирсэн ханын зургийг авран хамгаалах ажлыг 2008 оны 9 дүгээр сард гүйцэтгэн, Монголын Үндэсний музейд хүлээлгэн өгөв.

Дүгнэлт:

Соёлын өвийн төв нь төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан 2008 оны бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээгээр хүлээсэн 2 анги бүтээгдэхүүн нийлүүлэлтийг ханган ажиллалаа. Ялангуяа гэрээний тусгай захиалгат бүтээгдэхүүн Улс, аймгийн музейн улсын тооллогын дүнг нэгтгэн тайлагнах ажилд хамгийн их цаг хугацаа зарцуулан ажиллав.

Музейн сан хөмрөгийн улсын тооллого дуусч “Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай байгаа юм. Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэхэд музейнүүд бүртгэл хийх талаар сургалтаар бэлтгэсэн ажилтнуудаа тогтвор суурьшилтай ажиллуулах, интернет сүлжээнийхээ найдвартай ажиллагааг ханган ажиллах, бүртгэлийн програмаа бүрэн төгс эзэмших, соёлын өвийн талаарх бүртгэлийг үнэн зөв бүрдүүлэн, УНБМСанд иж бүрэн мэдээлэл ирүүлэх, хүлээлгэн өгсөн компьютер болон гэрэл зургийн аппарат хэрэгслийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллах чухал байна.

Монгол улсын Засгийн газрын 2007 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 303 дугаар тогтоолоор батлагдсан “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхэд төсөвт зардал орж ирэхгүй байгаа тул хөтөлбөр зогсонги байдалд хүрч болзошгүй байна.

Соёлын өвийн төв нь Соёлын төв өргөөний түрээсийн байранд байрладаг бөгөөд 2008 оны 7-р сарын 1-нд болсон үймээний үеэр сэргээн засварлах урлангийн 1 өрөө галд автан шатсанаас гэрээнд заасан “Бичигтийн амны хадны зурагт бэхжүүлэлт хийж хамгаалах, зарим онцлог дүрслэлийг хуулбарлан Дүрслэх урлагийн музейн эртний танхимд байрлуулах” ажил биелэгдээгүй, бүрэн зогссон. Гадны болзошгүй халдлага, эрсдлээс түүх, соёлын дурсгалыг

хамгаалахад мэргэжлийн байгууллагын ажиллах орчин нөхцлийг сайжруулах, “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөр”-т тусгагдсан Соёлын өвийг төвийг зориулалтын барилгатай болгох ажлыг холбогдох газрууд нэн даруй шийдвэрлэх нь чухал байна.

-х-

Монгол Улсын түүх, соёлын хосгүй үнэт зэрэглэлд батлагдсан
Өвөрхангай аймгийн Хархорин сумын Шанхын хийдийн дурсгал





Хэнтий, Сүхбаатар аймгийн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын нарийвчилсан бүртгэл, тооллогын ажил





Засварын өмнө



Засварын дараа

Архангай аймгийн Хотонт сумын нутаг Хундын хоолойн булшнаас олдсон ханын зургийн бэхжүүлэлт, сэргээн засварлалт



Архангай аймгийн Их тамир сумын нутаг дахь Тайхир чулууны бохирдолд хийсэн судалгаа



Архангай аймгийн Батцэнгэл сумын Луу гүний хүрээний барилгын гэмтэл тодорхойлох судалгааны ажил



Танилцуулга самбар байрлуулах дурсгал



Архангай аймгийн Их тамир сумын
Алтан сандал уулын дурсгал,
Улс, аймгийн музейн сан хөмрөгийн улсын тооллого



Архангай аймгийн Тариат сумын
Чулуутын голын хадны зураг
Улс, аймгийн музейн сан хөмрөгийн улсын тооллого





ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Хавсаргасан материал:

- Хэнтий, Сүхбаатар аймагт ажилласан тухай дэлгэрэнгүй тайлан
- 2008 онд сэргээн засварласан үзмэр бүтээлийн жагсаалт
- Сэргээн засварлах тайлангийн маягт А-гийн дагуу бичсэн сэргээн засварласан үзмэрийн тайланг жишээ болгон хавсаргасан
- Говь-Алтай аймгийн музейн үзмэрүүдээс хуулбар хийсэн ажлын тайлан
- Архангай Хотонт сумын Хундын хоолойн бунхант булшны ханын зургийг бэхжүүлэн сэргээн засварласан ажлын тайлан
- Баянлигийн хадны зургаас хэв авч хуулбар хийсэн ажлын тайлан
- Жанрайсиг бурхан сэргээн засварлах ажлын хүрээнд Дорнод аймагт ажилласан судалгааны багийн ажлын тайлан
- Монгол-Японы баг Хэнтий аймагт ажилласан ажлын тайлан
- БНХАУ-ын Ши-Ань мужийн соёлын өвийн төвд хийсэн сургалт, дадлагажилтын ажлын тайлан
- Хорват улсад туршлага судлах, дадлажих ажлын тайлан
- БНСУ-ын Тэжон хотын Соёлын өвийг судлах үндэсний хүрээлэнд хийсэн дадлагажих ажлын тайлан
- Улсын тооллогын нэгдсэн дүн
- Монголын Урлагийн зөвлөл, АНУ-ын Вильямстауны сэргээн засварлах төвийн хамтран зохион байгуулж буй соёлын солилцооны хөтөлбөрийн хүрээнд Монголын багийн АНУ-д хийсэн айлчлалийн тайлан
- Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Соёлын өвийн төвийн төлөөлөгчдийн БНСУ-д айлчилсан айлчлалын тайлан
- Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Соёлын өвийн төвийн мэргэжилтэнгүүдийн Япон улсын Токио хотын соёлын өвийг хамгаалах үндэсний судалгааны хүрээлэнд ажилласан ажлын тайлан